



**МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ**

14210 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Олимпийн гудамж 2, Засгийн газрын VIII багир,
Утас: 26-36-95, Факс: (976-11) 32-35-41, 32-05-16
И-мэйл: moh@moh.gov.mn, http://www.mohs.mn

2020.02.12 № 57710
танай _____-ны № _____-т

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ ХАРЪЯА
ТӨРӨЛЖСӨН МЭРГЭШЛИЙН ЭМНЭЛЭГ,
ТУСГАЙ МЭРГЭЖЛИЙН ТӨВ, АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГА /ЗАХИРАЛ/ НАРТ**

Эрүүл мэндийн салбарын 2020-2021 онд хамт
(тариф)-ын хэлэлцээрийг хэрэгжүүлэх хүрээнд Эрүүл
мэндийн сайдын "Хамтын хэлэлцээрийн хэрэгжилтийг
хангах тухай" А/69 дүгээр тушаал батлагдан гарсаныг
үүгээр хүргүүлж байна.

Дээрх тушаал болон хамтын хэлэлцээрийг
хэрэгжүүлж ажиллана уу.

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ГАЗРЫН ДАРГА Б.ЦОГТБААТАР



145201033



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2020 оны 02 сарын 08 өдөр

Дугаар А/69

Улаанбаатар хот

Хамтын хэлэлцээрийн хэрэгжилтийг хангах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Эрүүл мэндийн салбарын 2020-2021 оны хамт (тариф)-ын хэлэлцээрийн 5.8 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн салбарын 2020-2021 оны хамт(тариф)-ын хэлэлцээрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Эрүүл мэндийн яамны харьяа байгууллагын дарга, захирал болон Аймаг, Нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга нарт үүрэг болгсугай. Үүнд:

1.1. Эрүүл мэндийн ажилтны нийгмийн хамгааллын үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлж ажиллах, хэрэгжилтэд орон нутгийн Засаг захиргааны байгууллага, мэргэжлийн нийгэмлэг, холбоо, хувийн хэвшлийн байгууллагатай хамтрах;

1.2. Ажилтнуудын хөдөлмөрлөх эрх, шудрага ёс, ил тод байдлыг хангах үүднээс ажил олгогч нь байгууллагын шийдвэр гаргах түвшинд үйлдвэрчний эвлэлийн хорооны даргын оролцоог хангах үүднээс Удирдлагын багийн бүрэлдэхүүнд оруулах;

1.3. Засгийн газрын 2019 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн "Тогтоолын хавсралтд өөрчлөлт оруулах тухай" 395 дугаар тогтоолоор батлагдсан эрүүл мэндийн ажилтанд улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллыг олгох;

1.4. Хөдөлмөрийн тухай хуулийн 72.1 дэх заалтын дагуу 22 цагаас 06 цаг хүртэлх хугацаанд ажилласан эрүүл мэндийн ажилтнуудад "шөнийн цаг ажилласны нэмэгдэл"-ийг 1 цаг тутамд 1000 төгрөгөөр тооцон олгох;

1.5. Ур чадварын нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлтийг хангасан албан хаагчдад ур чадварын нэмэгдэл олгох;

1.6. Ажлын бус цагаар шөнийн ээлжинд ажиллаж буй эрүүл мэндийн ажилтанд оройн хоол, өглөөний цайг байгууллагын зардлаас олгож, хяналт тавих;

1.7. Эрүүл мэндийн байгууллага бүр 2020 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтныг орон тоогоор эсхүл гэрээгээр ажиллуулах асуудлыг цалингийн сандаа багтаан шийдвэрлэх;

1.8. "Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогын зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам"-ын хүрээнд ажилтанд нэмэгдэл хөлс, урамшуулал болон нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд 40-өөс доошгүй хувийг бүрэн зарцуулах;

2020-A-tushaal

141200247

1.9.Эрүүл мэндийн салбар хариуцлагатай албан тушаал болох Тасгийн эрхлэгч, ахлах сувилагч нарт хариуцлагын нэмэгдлийг үндсэн цалингийн 10-аас доошгүй хувиар, эд хөрөнгийн бүрэн хариуцлагын гэрээтэй эд хариулагч нарт үндсэн цалингийн 8-аас доошгүй хувийн нэмэгдэл хөлс олгох;

1.10.Эрүүл мэндийн салбарын ажлын онцлог байдал, ачааллыг харгалзан 100 хүртэл ажилтантай бол гэрээгээр, 100-аас дээш ажилтантай төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагад орон тооны, хувийн хэвшлийн байгууллагад орон тооны эсхүл гэрээт сэтгэл зүйч ажиллуулах асуудлыг цалингийн сандаа багтаан шийдвэрлэх;


1.11.Ажилтнуудад олгох нэг удаагийн буцалтгүй тэтгэмж, урамшууллыг хамтын гэрээгээр зохицуулан олгох;

1.12.Эрүүл мэндийн салбарын ажилтнуудын хөдөлмөрийн нөхцөл, мэргэжлийн онцлогт тохирсон иж бүрэн хувийн хамгаалах хувцас, хэрэгслээр хангах асуудлыг шийдвэрлэх;

1.13.Хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд ажилладаг ажилтанд хор саармагжуулах бодис, хүнсний бүтээгдэхүүнээр хангах болон ажлын цагийг богиносгох зохицуулалт хийх.

2.Энэхүү тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Я.Амаржаргал/, Төрийн захиргааны удирдлагын газрын дарга /Б.Цогтбаатар/ нарт үүрэг болгосугай.

САЙД



Д.САРАҢГЭРЭЛ